



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДГА-2025/93/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Цахим хаяг:	Т.Ган-Өлзий gan-ulziit@audit.gov.mn
Сайншанд сум 2026 он	Аудитын менежер: Цахим хаяг:	У.Оюунтүлхүүр oyuntulkhuur.u@audit.gov.mn
	Ахлах аудитор: Цахим хаяг:	О.Нарангарав narangarav.o@audit.gov.mn
	Аудитор: Цахим хаяг:	Н.Түвшинбаатар tuvshinbaatar@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншивэл сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (976) 7652 2734

Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2026.02.26 № 1-6/272

тантай _____ -ны № _____ -т

ХАТАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ О.СОДЦЭЦЭГ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хатанбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 184.7 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 31.5 сая төгрөгөөс давсан тул *Хязгаарлалттай дүгнэлт* өглөө.

Гэрэл, цахилгааны зардлаас интернэтийн төлбөр 0.2 сая төгрөгийг, түлш халаалтын зардлаас гэрэл цахилгааны төлбөр 0.4 сая төгрөгийг, бага үнэтэй түргэн элэгдэх бараа материалын зардлын данснаас шуудан холбооны төлбөр 0.09 сая төгрөгийг, автомашины оношилгооны төлбөр 0.05 сая төгрөгийг, бусад бараа, ажил үйлчилгээний зардлын данснаас программын төлбөр 0.7 сая төгрөгийг тус тус зориулалт бусаар зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-т *"батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"* гэж заасантай нийцэхгүй байна.

Тайлант оны авлагын 0.3 сая төгрөгийн, өглөгийн 62.2 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6 *"эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"* гэж заасантай нийцэхгүй байна.

442505183

Тайлант онд 9 удаа спортын уралдаан тэмцээн зохион байгуулахад 61.4 сая төгрөгийг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.8.-д "байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Тус байгууллага нь тайлант онд "Монголын тэмээн соёл, спорт уралдааны холбооны Дорноговь аймаг дахь салбар холбоо НҮББ" байгууллагад дэмжлэг 15.0 сая төгрөгийн үзүүлсэн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээд хуулиар зөвшөөрөөгүй, бусад зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно", 15.1.3 хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгохыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Тайлант онд өдрийн сонины тусгай дугаар 500 ширхгийг 1.0 сая төгрөгөөр захиалан авсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3-т "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээд хэвлэлийн захиалгын төлбөр төлөх зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Тус байгууллага нь шилэн дансны цахим системд хөрөнгө, мөнгө зарцуулах нийт 650.0 сая төгрөгийн 65 тушаал, шийдвэрээс 146.0 сая төгрөгийн 24 шийдвэрийг, цалингийн зардлаас бусад 5 саяас дээш үнийн дүнтэй 136.5 сая төгрөгийн зарлагын 14 гүйлгээнээс 74.4 сая төгрөгийн 8 гүйлгээг хугацаа хоцроож шилэн дансны цахим системд байршуулсан нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.5-т "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.8 "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" мэдээлнэ гэж заасантай нийцэхгүй байна.

Цалингийн зардлыг нийгмийн даатгалын 3-р сарын тайланд 1.0 сая төгрөгөөр, НДШ-ийн дүнг 0.13 сая төгрөгөөр, Татварын тайланд цалин хөлсний зардлыг 38.9 сая төгрөгөөр, ХАОАТ-ын дүнг 3.3 сая төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнасан нь Нийгмийн даатгалын тухай хууль 32.2.2-т "орон тоо болон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, сар бүр нийгмийн даатгалын санд төлөх", Хувь хүний орлогын албан албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1-т "ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого", 25 дугаар зүйлийн 25.4-т "Суутган төлөгч нь хувь хүнд орлого олгох бүрдээ түүний албан татвар төлөгчийн дугаар болон хувь хүн тус бүрээр олгосон орлого, түүнд ногдуулан суутгасан албан татварын хэмжээний мэдээллийг цахимаар, эсхүл хувь хүний орлого, татварын бүртгэлийн дэвтэрт тэмдэглэж, харьяа татварын албанд улрал тутам өссөн дүнгээр гаргаж илгээнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	393,734,873.47	395,036,085.58
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	18,297,467.00	38,297,467.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	18,297,467.00	38,297,467.00
3121	Төгрөг	18,297,467.00	38,297,467.00
31211	Төрийн сангийн харилцах	18,297,467.00	38,297,467.00
33	АВЛАГА	252,906,780.87	261,721,812.98
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	5,091,744.00	287,662.11
335	Бусад авлага	247,815,036.87	261,434,150.87
3351	Байгууллагаас авах авлага	247,815,036.87	261,434,150.87
35	БАРАА МАТЕРИАЛ	122,530,625.60	95,016,805.60
351	Түүхий эд материал	107,565,935.60	68,866,005.60
35110	Тусгай зориулалттай материал	107,565,935.60	68,866,005.60
354	Хангамжийн материал	12,364,690.00	23,850,800.00
35410	Бичиг хэргийн материал	4,713,680.00	4,452,690.00
35420	Аж ахуйн материал	1,565,010.00	1,365,510.00
35430	Сэлбэг хэрэгсэл	6,086,000.00	16,032,600.00
35440	Түлш, шатах тослох материал	-	2,000,000.00
35600	Мал амьтад	2,600,000.00	2,300,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,176,359,842.04	7,926,459,097.45
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,176,359,842.04	7,926,459,097.45
392	Биет хөрөнгө	6,028,995,842.04	7,779,215,097.45
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,077,365,473.70	5,470,738,744.50
39202	Хуримтлагдсан элэгдэл	- 372,656,217.99	- 588,055,465.13
39203	Авто-тээврийн хэрэгсэл	748,648,559.56	818,648,559.56
39204	Хуримтлагдсан элэгдэл	- 340,120,740.64	- 420,139,930.17
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	322,499,263.98	1,160,453,725.91
39206	Хуримтлагдсан элэгдэл	- 183,624,023.49	- 269,207,859.78
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	90,631,089.13	90,631,089.13
39208	Хуримтлагдсан элэгдэл	- 50,867,586.59	- 63,867,780.50
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,382,091,054.49	3,598,005,490.49
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,655,837,530.11	-2,028,857,976.56
39217	Ном	10,866,500.00	10,866,500.00
393	Биет бус хөрөнгө	147,364,000.00	147,244,000.00
39301	Програм хангамж	4,415,000.00	4,415,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	- 3,935,000.00	- 4,055,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	146,884,000.00	146,884,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	6,570,094,715.51	8,321,495,183.03
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	24,183,880.00	62,320,924.52
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	24,183,880.00	62,320,924.52
413	Өглөг	24,183,880.00	62,320,924.52
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	5,978,109.52
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	3,191,380.00	8,809,215.00
4136	Бусад өглөг	20,992,500.00	47,533,600.00
41361	Байгууллагад төлөх өглөг	20,938,500.00	44,199,600.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	54,000.00	3,334,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,545,910,835.51	8,259,174,258.51
51	Засгийн газрын хувь оролцоо	6,545,910,835.51	8,259,174,258.51
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,514,989,636.59	1,514,989,636.59
512	Хуримтлагдсан үр дүн	4,863,957,580.07	6,577,221,003.07
51210	Өмнөх үеийн үр дүн	4,863,957,580.07	4,863,957,580.07
51220	Тайлант үеийн үр дүн	-	1,713,263,423.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	166,963,618.85	166,963,618.85
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	6,570,094,715.51	8,321,495,183.03

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,082,145,713.85	4,400,142,484.78
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,588,344,084.00	2,689,713,992.78
120	Нийтлэг татварын бус орлого	2,588,344,084.00	2,689,713,992.78
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,452,000.00	8,912,574.05
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,452,000.00	8,912,574.05
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	2,348,492,084.00	2,661,862,168.73
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	236,400,000.00	18,939,250.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,493,801,629.85	1,710,428,492.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,168,435,006.00	85,380,092.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,079,672,803.00	24,864,540.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	88,762,203.00	60,515,552.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,325,366,623.85	1,625,048,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,325,366,623.85	1,625,048,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,151,560,390.32	2,538,754,061.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,151,560,390.32	2,538,754,061.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,133,375,640.32	2,384,444,287.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	810,618,554.03	917,403,879.72
210101	Үндсэн цалин	426,150,426.13	465,085,539.45
210102	Нэмэгдэл	311,646,327.90	349,376,422.56
210103	Унаа хоолны хөнгөлөлт	49,290,000.00	67,791,767.71
210104	Урамшуулал	23,531,800.00	35,150,150.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	101,539,687.61	112,959,158.86
210201	Тэтгэврийн даатгал	68,279,346.83	77,580,471.90
210202	Тэтгэмжийн даатгал	8,180,764.33	9,094,793.63
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,050,782.18	4,714,031.65
210204	Ажилгүйдлийн даатгал	3,696,584.48	4,311,572.80
210205	Эрүүл мэндийн даатгал	17,332,209.79	17,258,288.88
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	61,168,800.68	70,695,095.99
210301	Гэрэл, цахилгаан	15,795,661.21	26,198,754.81
210302	Түлш, халаалт	41,333,915.47	35,914,709.18
210303	Цэвэр, бохир ус	4,039,224.00	8,581,632.00
2104	Хангамж, бараа материалын зардал	373,641,531.00	83,513,380.00
210401	Бичиг хэрэг	3,539,420.00	5,682,990.00
210402	Тээвэр, шатахуун	65,322,311.00	53,403,095.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,757,350.00	3,727,315.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	300,902,450.00	20,632,980.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	67,000.00
2105	Нормативт зардал	59,571,600.00	35,819,390.00
210502	Хоол, хүнс	59,571,600.00	35,819,390.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,301,700.00	8,744,600.00
210604	Урсгал засвар	25,301,700.00	8,744,600.00
2107	Томилолт, зочны зардал	23,247,800.00	9,160,000.00
210702	Дотоод албан томилолт	23,247,800.00	9,160,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	749,848,334.50	341,476,079.29
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	744,771,713.50	340,431,926.29
210803	Даатгалын үйлчилгээ	596,275.00	712,545.00

210804	Тээврийн хэрэгслийн татвар	374,140.00	113,608.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	286,000.00	218,000.00
210807	Газрын төлбөр	3,820,206.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	928,437,632.50	804,672,703.32
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	290,091,614.00	5,654,790.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,000,090.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	625,345,928.50	799,017,913.32
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,184,750.00	154,309,774.60
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,184,750.00	13,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	18,184,750.00	13,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	141,309,774.60
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	141,309,774.60
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,930,585,323.53	1,861,388,423.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	78,500.01	148,125,000.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	0.01	-
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал- Үндсэн хөрөнгө	78,500.00	148,125,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	- 78,500.01	- 148,125,000.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,930,506,823.52	1,713,263,423.00

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,600,618,515.72	1,997,147,852.92
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,382,168.00	38,912,574.05
120	Нийтлэг татварын бус орлого	12,382,168.00	38,912,574.05
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,452,000.00	8,912,574.05
120004 2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,452,000.00	8,912,574.05
120009	Бусад орлого	8,930,168.00	30,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,588,236,347.72	1,958,235,278.87
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,262,869,723.87	333,186,878.87
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,079,672,803.00	24,864,540.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	183,196,920.87	308,322,338.87
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,325,366,623.85	1,625,048,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,325,366,623.85	1,625,048,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,322,979,230.85	1,941,767,852.92
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,322,979,230.85	1,941,767,852.92
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,314,756,480.85	1,526,023,927.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	838,860,701.71	941,205,392.70
210101	Үндсэн цалин	397,289,936.42	452,156,982.51
210102	Нэмэгдэл	358,406,965.29	386,106,492.48
210103	Унаа хоолны хөнгөлөлт	49,090,000.00	67,791,767.71
210104	Урамшуулал	34,073,800.00	35,150,150.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	106,085,368.96	108,676,614.79
210201	Тэтгэврийн даатгал	74,745,363.87	75,954,390.27
210202	Тэтгэмжийн даатгал	7,323,965.41	8,427,243.01
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,937,961.80	4,376,296.37
210204	Ажилгүйдлийн даатгал	1,937,183.36	3,981,337.50
210205	Эрүүл мэндийн даатгал	17,140,894.52	15,937,347.64
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	61,168,800.68	69,097,176.04
210301	Гэрэл, цахилгаан	15,795,661.21	26,278,774.86

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210302	Түлш, халаалт	41,373,515.47	34,236,769.18
210303	Цэвэр, бохир ус	3,999,624.00	8,581,632.00
2104	Хангамж, бараа материалын зардал	73,646,081.00	42,604,015.00
210401	Бичиг хэрэг	4,915,400.00	3,011,760.00
210402	Тээвэр, шатахуун	62,964,331.00	34,818,040.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,830,850.00	3,507,315.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,815,500.00	1,266,900.00
2105	Нормативт зардал	350,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	350,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,112,200.00	13,716,600.00
210604	Урсгал засвар	23,112,200.00	13,716,600.00
2107	Томилолт, зочны зардал	21,897,800.00	9,790,000.00
210702	Дотоод албан томилолт	21,897,800.00	9,790,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,056,484,048.50	332,393,338.92
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,051,407,427.50	331,349,185.92
210803	Даатгалын үйлчилгээ	596,275.00	712,545.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	374,140.00	113,608.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	286,000.00	218,000.00
210807	Газрын төлбөр	3,820,206.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	133,151,480.00	8,540,790.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	120,053,800.00	7,015,790.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,097,680.00	1,525,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,222,750.00	415,743,925.47
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,222,750.00	13,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,222,750.00	13,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	141,309,774.60
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	141,309,774.60
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	261,434,150.87
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	261,434,150.87
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	277,639,284.87	55,380,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	27,485,080.00	35,380,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	27,485,080.00	35,380,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	27,485,080.00	35,380,000.00
222001	Тоног төхөөрөмж	10,085,000.00	9,500,000.00
223001	Бусад хөрөнгө	17,400,080.00	25,880,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	- 27,485,080.00	- 35,380,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	250,154,204.87	20,000,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		18,297,467.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	18,297,467.00	38,297,467.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	төгрөгөөр
					Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
С01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	1,514,989,636.59	167,046,779.15	2,933,367,596.25	4,615,404,011.99

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	83,160.30	83,160.30
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,514,989,636.59	167,046,779.15	2,933,450,756.55	4,615,487,172.29
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	83,160.30	-	83,160.30
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	1,930,506,823.52	1,930,506,823.52
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,514,989,636.59	166,963,618.85	4,863,957,580.07	6,545,910,835.51
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,514,989,636.59	166,963,618.85	4,863,957,580.07	6,545,910,835.51
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,514,989,636.59	166,963,618.85	4,863,957,580.07	6,545,910,835.51
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	1,713,263,423.00	1,713,263,423.00
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,514,989,636.59	166,963,618.85	6,577,221,003.07	8,259,174,258.51

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,602,048,400.00	1,492,651,199.45	109,397,200.55	93.2%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,602,048,400.00	1,492,651,199.45	109,397,200.55	93.2%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,594,748,400.00	1,492,651,199.45	102,097,200.55	93.6%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	922,470,600.00	941,205,392.70	-18,734,792.70	102.0%
210101	Үндсэн цалин	454,408,000.00	452,156,982.51	2,251,017.49	99.5%
210102	Нэмэгдэл	370,839,600.00	386,106,492.48	-15,266,892.48	104.1%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	62,554,200.00	67,791,767.71	- 5,237,567.71	108.4%
210104	Урамшуулал	34,668,800.00	35,150,150.00	- 481,350.00	101.4%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	115,308,800.00	108,676,614.79	6,632,185.21	94.2%
210201	Тэтгэврийн даатгал	74,610,000.00	75,954,390.27	- 1,344,390.27	101.8%
210202	Тэтгэмжийн даатгал	10,174,700.00	8,427,243.01	1,747,456.99	82.8%

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210203	ҮОМШӨ-ний даатгал	5,087,300.00	4,376,296.37	711,003.63	86.0%
210204	Ажилгүйдлийн даатгал	5,087,300.00	3,981,337.50	1,105,962.50	78.3%
210205	Эрүүл мэндийн даатгал	20,349,500.00	15,937,347.64	4,412,152.36	78.3%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	70,237,400.00	69,097,176.04	1,140,223.96	98.4%
210301	Гэрэл, цахилгаан	29,800,000.00	26,278,774.86	3,521,225.14	88.2%
210302	Түлш, халаалт	32,377,900.00	34,236,769.18	- 1,858,869.18	105.7%
210303	Цэвэр, бохир ус	8,059,500.00	8,581,632.00	- 522,132.00	106.5%
2104	Хангамж, бараа материалын зардал	54,873,600.00	36,778,455.00	18,095,145.00	67.0%
210401	Бичиг хэрэг	3,921,500.00	3,011,760.00	909,740.00	76.8%
210402	Тээвэр, шатахуун	41,788,100.00	28,992,480.00	12,795,620.00	69.4%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,224,000.00	3,507,315.00	3,716,685.00	48.6%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	140,000.00	-	140,000.00	0.0%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,800,000.00	1,266,900.00	533,100.00	70.4%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	65,700,000.00	23,216,600.00	42,483,400.00	35.3%
210601	Багаж, техник, хэрэгсэл	29,500,000.00	9,500,000.00	20,000,000.00	32.2%
210604	Урсгал засвар	36,200,000.00	13,716,600.00	22,483,400.00	37.9%
2107	Томилолт, зочны зардал	12,550,000.00	9,160,000.00	3,390,000.00	73.0%
210702	Дотоод албан томилолт	12,550,000.00	9,160,000.00	3,390,000.00	73.0%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	345,208,000.00	296,976,170.92	48,231,829.08	86.0%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	337,800,000.00	295,932,017.92	41,867,982.08	87.6%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	330,000.00	-	330,000.00	0.0%
210803	Даатгалын үйлчилгээ	720,000.00	712,545.00	7,455.00	99.0%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,140,000.00	113,608.00	1,026,392.00	10.0%
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	218,000.00	218,000.00	-	100.0%
210807	Газрын төлбөр	5,000,000.00	-	5,000,000.00	0.0%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,400,000.00	7,540,790.00	859,210.00	89.8%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,500,000.00	6,015,790.00	- 515,790.00	109.4%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,900,000.00	1,525,000.00	1,375,000.00	52.6%

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,300,000.00	-	7,300,000.00	0.0%
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,300,000.00	-	7,300,000.00	0.0%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,300,000.00		7,300,000.00	0.0%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,602,048,400.00	1,633,960,974.05	-31,912,574.05	102.0%
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,595,048,400.00	1,625,048,400.00	-30,000,000.00	101.9%
132001	Орон нутгийн төсвөөс	1,595,048,400.00	1,625,048,400.00	-30,000,000.00	101.9%
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	7,000,000.00	8,912,574.05	- 1,912,574.05	127.3%
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,000,000.00	8,912,574.05	- 1,912,574.05	127.3%

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	71,752,728.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	71,752,728.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	68,752,728.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,825,560.00
210402	Тээвэр, шатахуун	5,825,560.00
2107	Томилолт, зочны зардал	630,000.00
210702	Дотоод албан томилолт	630,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	61,297,168.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	61,297,168.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	333,186,878.87
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	333,186,878.87
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	24,864,540.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	308,322,338.87

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 5,194.5 сая төгрөгийн 10 алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 5,009.8 сая төгрөгийн 2 алдааг залруулсан. Үүнд:

3.1 Залруулсан алдаа

1. Санхүүгийн байдлын тайланд: Үндсэн хөрөнгийн дүнг 435.8 сая төгрөгөөр дутуу, өглөгийн дүнг 6.0 сая төгрөгөөр дутуу, тайлант үеийн үр дүнг 429.8 сая төгрөгөөр дутуу, Санхүүгийн үр дүнгийн тайланд: үйл ажиллагааны орлогын дүнг 2,689.7 сая төгрөгөөр дутуу, урсгал зардлын дүнг 4.0 сая төгрөгөөр дутуу, Мөнгөн гүйлгээний тайланд: үйл ажиллагааны орлогын дүнг 0.03 сая төгрөгөөр дутуу, нийт зарлагын дүнг 0.03 сая төгрөгөөр дутуу, Төсвийн гүйцэтгэлийн тайланд: нийт зардлын батлагдсан төлөвлөгөөг 343.3 сая төгрөгөөр дутуу, урсгал зардлын гүйцэтгэлийн дүнг 474.5 сая төгрөгөөр дутуу тусгаж тайлагнасан байна.

2. Төсвийн гүйцэтгэлийн тайланд: зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн батлагдсан төлөвлөгөөг 626.6 сая төгрөгөөр дутуу тусгаж тайлагнасан байна. Сумын ИТХ-ын тогтоолд орон нутгийн төсвөөс санхүүжих дүнг 37.8 сая төгрөгөөр алдаатай тусгаж баталсан байна.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 184.7 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 31.5 сая төгрөгөөс давсан тул *Хязгаарлалттай дүгнэлт* өглөө.

Аудитаар илэрсэн нийт 184.7 сая төгрөгийн 8 зөрчилд 141.3 сая төгрөгийн 7 албан шаардлага, 43.4 сая төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлэв.

3.2 Албан шаардлага

1. Тайлант онд 9 удаа спортын уралдаан тэмцээн зохион байгуулахад 61.4 сая төгрөгийг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.8.-д *"байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулахыг хориглоно"* гэж заасантай нийцэхгүй байна.

2. Тус байгууллага нь тайлант онд "Монголын тэмээн соёл, спорт уралдааны холбооны Дорноговь аймаг дахь салбар холбоо НҮББ" байгууллагад 15.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээд хуулиар зөвшөөрөөгүй, бусад зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно", 15.1.3 хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгохыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

3. Гэрэл, цахилгааны зардлаас интернэтийн төлбөр 0.2 сая төгрөгийг, түлш халаалтын зардлаас гэрэл цахилгааны төлбөр 0.4 сая төгрөгийг, бага үнэтэй түргэн элэгдэх бараа материалын зардлын данснаас шуудан холбооны төлбөр 0.09 сая төгрөгийг, автомашины оношилгооны төлбөр 0.05 сая төгрөгийг, бусад бараа, ажил үйлчилгээний зардлын данснаас программын төлбөр 0.7 сая төгрөгийг тус тус зориулалт бусаар зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-т *"батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"* гэж заасантай нийцэхгүй байна.

4. Тайлант оны авлагын 0.3 сая төгрөгийн, өглөгийн 62.2 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6 *"эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"* гэж заасантай нийцэхгүй байна.

5. Тайлант онд өдрийн сонины тусгай дугаар 500 ширхгийг 1.0 сая төгрөгөөр захиалан авсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3-т “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээд хэвлэлийн захиалгын төлбөр төлөх зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно” гэж заасантай нийцэхгүй байна.

6. Шилэн дансны цахим системд хөрөнгө, мөнгө зарцуулах нийт 650.0 сая төгрөгийн 65 тушаал, шийдвэрээс 146.0 сая төгрөгийн 24 шийдвэрийг, цалингийн зардлаас бусад 5 саяас дээш үнийн дүнтэй 136.5 сая төгрөгийн зарлагын 14 гүйлгээнээс 74.4 сая төгрөгийн 8 гүйлгээг хугацаа хоцроож шилэн дансны цахим системд байршуулсан нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.4.5-т “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6.4.8 “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” мэдээлнэ гэж заасантай нийцэхгүй байна. Мөн өмнөх оны аудитаар илэрсэн зөрчлийг давтан гаргасан байна.

7. Тус байгууллага нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй аудитын үйл ажиллагаанд саад учруулж, албан үүргээ биелүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т “*төсвийн шууд захирагч жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх*”, Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т “*Энэ хуулийн 16 зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно*” гэж заасантай нийцэхгүй байна гэж заасантай нийцэхгүй байна.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1 Ажил гүйлгээний ангитай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Цалингийн зардлыг нийгмийн даатгалын 3-р сарын тайланд 1.0 сая төгрөгөөр, НДШ-ийн дүнг 0.13 сая төгрөгөөр, Татварын 4-р улирлын тайланд цалин, хөлсний зардлыг 38.9 сая төгрөгөөр, ХАОАТ-ын дүнг 3.3 сая төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнасан нь Нийгмийн даатгалын тухай хууль 32.2.2-т “*орон тоо болон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, сар бүр нийгмийн даатгалын санд төлөх*”, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1-т “*ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж,*

тэдгээртэй адилтгах бусад орлого”, 25 дугаар зүйлийн 25.4-т “Суутган төлөгч нь хувь хүнд орлого олгох бүрдээ түүний албан татвар төлөгчийн дугаар болон хувь хүн тус бүрээр олгосон орлого, түүнд ногдуулан суутгасан албан татварын хэмжээний мэдээллийг цахимаар, эсхүл хувь хүний орлого, татварын бүртгэлийн дэвтэрт тэмдэглэж, харьяа татварын албанд улирал тутам өссөн дүнгээр гаргаж илгээнэ” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Цаашид тооцоолсон цалин, хөлсний зардал, суутгалын дүнг холбогдох тайланд залруулж, зөрүүгүй тайлагнаж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 09 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				/мянган, төгрөгөөр/ Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүүгийн тайланг алдаатай илэрхийлсэн	1	4,383,224.0	-	-	1	4,383,224.0	1	4,383,224.0	-	-	-	-
Орлогын батлагдсан төлөвлөгөөг алдаатай тусгасан байна.	1	626,619.1	-	-	1	626,619.1	1	626,619.1	-	-	-	-
Дүн	2	5,009,843.1	-	-	2	5,009,843.1	2	5,009,843.1	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								/мянган, төгрөгөөр/	
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн		Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.	1	62,518.6			1	62,518.6						
Батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан.	1	1,441.2			1	1,441.2						
Цалингийн зардал, суутгалын дүнг нийгмийн даатгалын болон татварын тайланд алдаатай тусгасан.	1	43,396.0					1	43,396.0				
Дүн	3	107,355.8			2	63,959.8	1	43,396.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны хэрэгжилт хангалтгүй.	1	-	-	-	1	-	-	-
Дүн	1	-	-	-	1	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Байгууллагын хөрөнгөөр спортын уралдаан, тэмцээн зохион байгуулсан	1	61,360.0	-	-	1	61,360.0	-	-
Төрийн бус байгууллагад хуульд заагдаагүй дэмжлэг үзүүлсэн.	1	15,000.0	-	-	1	15,000.0	-	-
Байгууллагын хөрөнгөөр сонин захиалсан.	1	1,000.0	-	-	1	1,000.0	-	-
Дүн	3	77,360.0	-	-	3	77,360.0	-	-
Нийт дүн	4	77,360.0	-	-	4	77,360.0	-	-